



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын хураангуй тайлан

**АУДИТЫН СЭДЭВ: “ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД ДҮГНЭЛТ
ӨГӨХ”**

АУДИТЫН ГОЛ ДҮГНЭЛТ: ОРОН НУТГИЙН 2025 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГО,
ЗАРЛАГЫН ТӨСВИЙГ ҮНДЭСЛЭЛТЭЙ ТӨЛӨВЛӨХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Аудитын тайланг хүргүүлсэн этгээд: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

Нэмэлт мэдээлэл, мэдээллийн эх сурвалж:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар
авна уу.

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ж.Айгүл

Утас: 70422954 Цахим хаяг: aijulj@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Назгүл

Утас: 99427301 Цахим хаяг: nazguld@audit.gov.mn

Ахлах аудитор: У.Ербол

Утас: 99425121 Цахим хаяг: erbolu@audit.gov.mn

Аудитор: М.Айнур

Утас: 99423031 Цахим хаяг: ainurm@audit.gov.mn

Аудитор: Б.Үүрийнтуяа

Утас: 90832211 Цахим хаяг: uuriintuyab@audit.gov.mn

Аудитор Ж.Назгүл

Утас: 99668909, Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn

Аудитор: Х.Еркебулан

Утас: 99999844 Цахим хаяг: erkebulankh@audit.gov.mn

Аудитор: Р. Баярмаа

Утас: 99265539 Цахим хаяг: bayarmaar@audit.gov.mn

Аудитор: Ш.Нурлан

Утас: 99422966 Цахим хаяг: nurlanSH@audit.gov.mn

2025 оны 12 дугаар сар

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын
байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2024 оны “Аудитын

жилийн төлөвлөгөө батлах тухай” А/108 дугаар тушаал, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын 2025 онд гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн гүйцэтгэв

Аудитын зорилго, зорилтууд, хамарсан хүрээ:

“Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудит”-аар Баян-Өлгий аймгийн Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд дүгнэлт гаргаж, санал зөвлөмж боловсруулан, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Орон нутгийн 2025 оны төсвийн орлогын төлөвлөлт үндэслэлтэй боловсруулсан эсэх;
- Орон нутгийн 2025 оны төсвийн зарлагын төлөвлөлт үндэслэлтэй боловсруулсан эсэх;
- Орон нутгийн 2025 оны хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг хууль журамд нийцүүлэн төлөвлөсөн эсэх

Аудитад аймгийн Засаг дарга, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн санхүүгийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Татварын хэлтэс болон бусад холбогдох байгууллагуудын төсвийн төлөвлөлттэй холбоотой судалгаа, мэдээ, баримт материалыг хамруулав.

Аудит хийхэд гарсан хүндрэл бэрхшээл: Хүндрэл бэрхшээл Төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитыг Төсвийн тухай хуульд заасан 5 хоногийн хугацаанд гүйцэтгэдэг байдал нь мэдээллийг бүрэн шинжлэх, иж бүрэн дүгнэлт гаргах аудитын үйл ажиллагаа хязгаарлагддаг юм. Мөн шалгаагдагч байгууллагуудаас шаардлагатай мэдээ, судалгаа, тоо баримтыг шаардсан хугацаанд иж бүрэн ирүүлдэггүй байдал, Санхүү, төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтсээс зөрүүтэй тоо, судалгаа ирүүлсэн нь хүндрэлтэй байлаа.

Аудит хийсэн багийн бүрэлдэхүүн: Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Назгүл, У.Ербол, аудитор М.Айнур, Б.Үүрийнтуяа, Ж.Назгүл, Х.Еркебулан, Р.Баярмаа, Ш.Нурлан нарын бүрэлдэхүүнтэй баг хамтран гүйцэтгэв.

Аудитын гол үр дүн:

БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ОРЛОГЫГ БОДИТ ТООЦОО СУДАЛГААНД ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

1.1. Орон нутгийн 2024 оны орлогын төлөвлөгөө хүлээгдэж буй гүйцэтгэлээр тасрах төлөвтэй байна.

Аймгийн ИТХ-ын 2024 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 262 дугаар тогтоолоор орон нутгийн 2024 оны орлогыг анх баталснаас 11,318.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 38,481.9 сая төгрөгөөр, 41.7 хувиар нэмэгдүүлж тодотгож баталсан байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 4,023.5 сая төгрөгөөр тасрах төлөвтэй байгаагаас татварын орлого 2,521.7 сая төгрөгөөр, татварын бус орлого 1,501.8 сая төгрөгөөр тасрахаар байна. Орлогын нэр төрлөөр задалж авч үзвэл:

- Татварын орлогоос цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар, үйл ажиллагааны орлогын татвар, малын татвар, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны татвар, хог хаягдлын үйлчилгээний хураамж, ойгоос мод, түлээ бэлтгэж ашигласны төлбөр, ан ашигласны төлбөр, ан амьтан барих эрхийн хураамжийн орлогууд тасрах төлөвтэй байна.
- Татварын бус орлогоос төсөвт газрын өөрийн орлого, хүүгийн орлого, торгуулийн орлого, бусад орлогууд тасрах төлөвтэй байна.

1.2 Аймгийн төсвийн төсөлд нийт орлогыг 82,075.1 сая төгрөгөөр төлөвлөж ирүүлсэн байна

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар баталсан Монгол Улсын 2025 оны Төсвийн тухай хуулиар Баян-Өлгий аймагт улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 29,659.7 сая төгрөг, Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 14,026.4 сая төгрөгөөр баталсан байна.

Сангийн яамны хянаж ирүүлсэн 2025 оны орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг аймгийн орон нутгийн орлогын 2024 оны тодотгосон төсөвтэй харьцуулахад 4,135.8 сая төгрөгөөр бага байна.

Аймгийн Засаг даргын дүгнэлт гаргуулахаар ирүүлсэн орон нутгийн 2025 оны төсвийн орлогын төлөвлөгөөг Сангийн яамны хянасан дүнтэй харьцуулахад 4,043.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Аймгийн орон нутгийн 2025 оны төсвийн орлогод орлого нэмэгдүүлэх боломжуудыг бүрэн судалж төлөвлөлтийг сайжруулах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй буюу зөвхөн биелэх боломжтой татвар болох цалин хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, ангийн орлого зэрэг орлогуудыг нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

1.3 Аймгийн орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд орлогыг 1,670.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна

Аймгийн орон нутгийн орлогын 2023 оны гүйцэтгэл, 2024 оны төлөвлөгөө, хүлээгдэж буй гүйцэтгэл, Сангийн яамны хянасан дүн зэрэгт үндэслэж төсвийн орлогыг 1,670.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна гэж үзсэн. Тухайлбал:

Үйл ажиллагааны орлогыг 450.0 сая төгрөгөөр, хөрөнгийн орлогыг 100.0 сая төгрөгөөр, аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг 120.0 сая төгрөгөөр, малын тоо, толгойн татварыг 700.0 сая төгрөгөөр, газрын төлбөрийн орлогыг 200.0 сая төгрөгөөр, бусад нэр заагдаагүй орлогыг 100.0 сая төгрөгөөр, нийтдээ **1,670.0** сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.

2.1 Аймгийн Засаг дарга Орон нутгийн 2025 оны төсвийн суурь зарлагыг 4,261.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна

Баян-Өлгий аймгийн орон нутгийн 2025 оны төсвийн зарлагыг өмнөх төсвөөс 4,750.5 сая төгрөгөөр бууруулж 63,787.8 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн байна. Үүнээс: бараа, үйлчилгээний зардлыг 3,976.3 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 735.4 сая төгрөгөөр бууруулсан байна.

Аймгийн Засаг даргаас боловсруулсан 2025 оны орон нутгийн төсвийн төсөлд орон нутгийн суурь зарлагыг 68,048.9 сая төгрөгөөр төлөвлөж Сангийн яамны хянасан дүнгээс 4,261.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Аймгийн ИТХ-ын төсвийг 249.6 сая төгрөгөөр, Аймгийн Засаг даргын төсвийг 6,051.6 сая төгрөгөөр, Орон нутгийн хөрөнгө оруулалтын төсвийг 1,415.0 сая төгрөгөөр, МҮОНРТ-ийн Баян-Өлгий дахь салбарын төсвийг 117.3 сая төгрөгөөр, Орон нутгийн өмчийн газрын төсвийг 190.5 сая төгрөгөөр, Сум дундын ойн ангийн төсвийг 101.5 сая төгрөгөөр, Худалдан авах хэлтсийн төсвийг 97.8 сая төгрөгөөр, СӨБ-ийн тогтмол зардлыг 448.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Төсвийн төслийг нийт дүнгээр 4,261.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн нь төрийн албан хаагчдын цалингийн зардал, тогтмол зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

2.2 Цалингийн зардлын төсвийн төлөвлөлтийн талаар

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагуудын 2025 оны цалингийн зардлын төсвийг 27,290.6 сая төгрөгөөр төлөвлөж, Сангийн яамнаас хянасан дүнгээс 3,190.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Сангийн яамнаас хянасан орон тооны хязгаар 580 байгаа бөгөөд 2025 оны төсвийн төсөлд 691 орон тоо буюу 111-аар илүү байна. Сумын Засаг даргын тамгын газруудад 44, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд 8, Аймгийн Засаг даргын тамгын газарт 33, Байгаль орчин аялал жуулчлалын газарт 7, Орон нутгийн өмчийн газарт 9, Худалдан авах ажиллагааны газарт 7, Сум дундын ойн ангид 1, Орон нутгийн олон нийтийн радио телевизэд 2 орон тоо хязгаараас илүү харагдаж байна. Энэ нь орон нутгаас зарим орон тоог нэмж ажиллуулж байгаатай холбоотой.

Аймгийн ЗДТГ-ын бүтэц орон тооны талаар: Аймгийн ЗДТГ-ын даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 01, 02 дугаар тушаалаар бүтэц орон тоог 122 хүнээр баталсан. Үүнд: төрийн захиргааны 46, төрийн тусгай 4, улс төрийн 2, төрийн үйлчилгээний 70 албан хаагч ажиллахаар баталсан байна. Төрийн үйлчилгээний албан хаагчдын ЗДТГ-т 45, төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн байранд 12, хохирогчдод үйлчлэх нэг цэгийн төвд 6, архивын тасагт 7 нийтдээ 70 орон тоог ажиллуулж байгаа нь төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын байрны ачаалал, нягтралыг тооцож ажиллуулж байгаа нь тодорхойгүй байна.

Цалингийн зардлын төсвийн төлөвлөлтийг сайжруулах төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэхтэй холбоотой дараах саналыг хүргэж байна. Үүнд:

1. Ажлын байрны нягтралыг сайжруулах цалингийн зардалтай холбоотой үр ашиггүй зардлыг бууруулах;

2. Улсын төсвийн байгууллагуудын албан хаагч нарт олгох орон нутгийн нэмэгдлийг орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлтэй уялдуулах, гарч болох эрсдэлийг урьдчилан тооцож ажиллах;

2.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын 2025 оны төсвийн талаар:

Сангийн яамнаас орон нутгийн 2025 оны төсөвт байр ашиглалттай холбоотой зардлын нийт төсвийг 19,632.8 сая төгрөгөөр хянаж ирүүлснээс гэрэл цахилгааны зардлын төсвийг 1,557.6 сая төгрөг, түлш халаалтын зардлын төсвийг 16,957.3 сая төгрөг, цэвэр бохир усны зардлын төсвийг 1,117.8 сая төгрөг байхаар төлөвлөжээ.

Төсвийн төсөлд байр ашиглалттай холбоотой зардлыг 411.2 сая төгрөгөөр бууруулж 19,221.6 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Байр ашиглалттай холбоотой зардлын төсвөөс 1,792.2 сая төгрөгийг дулааны үнэ тарифын нэмэгдлээс үүсэх зөрүүд олгохоор тооцож Засаг даргын ерөнхий дансанд тусгасан байна. Үүнээс гэрэл цахилгааны зардал 314.6 сая, түлш халаалтын зардал 1360.0 сая, цэвэр бохир усны зардал 117.7 сая төгрөг байна.

Аудитаар гэрэл цахилгаан болон түлш, халаалтын зардлын өссөн, буурсан шалтгааныг тодруулж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Гэрэл цахилгааны зардлын 2024 оны тодотгосон төсөв нь 965.8 сая төгрөг болж өмнөх оноос 405.0 сая төгрөг буюу 72.2 хувиар өссөн нь Эрчим хүчний зохицуулах хорооны 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 512 дугаар тогтоолоор төсвийн байгууллагын цахилгааны тарифыг нэмэгдүүлж 2023 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдсөнтэй холбоотой байна.

Түлш, халаалтын зардлын 2024 оны тодотгосон төсөв 13,517.9 сая төгрөг болж өмнөх оноос 4,164.6 сая төгрөг буюу 44.5 хувиар өссөн нь Эрчим хүчний зохицуулах хорооны 08 дугаар сарын 16-ны өдөр баталсан 537 дугаар тогтоол болон аймгийн Зохицуулах зөвлөлийн 2023 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 23/08, 23/09, 23/10, 23/11, 23/12, 23/13, 23/14, 23/1523/16, тогтоолуудаар аймаг, сумын хэрэглэгчдэд олгох дулааны эрчим хүчний тарифыг нэмэгдүүлж 2024 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдөж ажилласантай холбоотой байна.

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийн төлөвлөлтийг сайжруулах, төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэхтэй холбоотой дараах саналыг хүргэж байна. Үүнд:

1. Шүүхийн шийдвэрээр төлөх он дамжсан халаалтын зардлын өр төлбөрийг тухайн байгууллагуудын төсөвт суулган бүрэн барагдуулах арга хэмжээ авах;

2. Төсөвт байгууллагуудын халаалтын талбайн эзлэхүүнийг хянан баталгаажуулж, халаалтын зардлын төсвийг бодитой төлөвлөхөд анхаарах;

3. Сумуудын нэгдсэн халаалтын үнэ тарифыг үндэслэлтэй тогтоосон эсэхийг хянаж үзэх шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 1,310.0 САЯ ТӨГРӨГИЙН ТӨСӨВТ ӨРТӨГТЭЙ 11 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ХУУЛЬД ЗААСАН ШААРДЛАГЫГ ХАНГААГҮЙ БАЙНА

3.1 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-гийн төсөл арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөх шаардлагатай байна

Сангийн яамнаас аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны төсвийг 14,026.3 сая төгрөгөөр хянаж ирүүлсэн. Үүнээс аймгийн ОНХС-д 5,346.2 сая төгрөг, сумдын ОНХС-д 8,680.1 сая төгрөг хуваарилсан байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн санд он дамжсан шилжих хөрөнгө оруулалтад 896.6 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ, шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтад 4,449.6 сая төгрөгийн 47 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Шинээр төлөвлөсөн 47 төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хууль, ОНХС-ийн журмын хүрээнд төлөвлөсөн эсэхийг хянаж үзэхэд 480.0 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээ шаардлага хангаагүй байна.

Аймгийн 2025 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх 21 төсөл арга хэмжээнд 1,415.0 сая төгрөг, их засварын ажилд шилжих хөрөнгө оруулалтаар 7 төсөл арга хэмжээнд 193.9 сая төгрөг, шинээр хэрэгжүүлэх 38 төсөл арга хэмжээнд 6,424.3 сая төгрөг төлөвлөсөн байна.

Төсвийн хөрөнгө орон нутгийн төсөлд зарлага бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх дараах саналуудыг хүргүүлж байна. Үүнд:

1. Иргэдийн санал аваагүй, аймгийн ОНХС-ийн чиг үүрэгт хамааралгүй, тооцоо, судалгаагүй, шаардлага хангаагүй **480.0** сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээг хасах;
2. Аймгийн ЗДТГ-ын болон ИТХ-ын мэргэжилтнүүдийг компьютер, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлоор хангахад төлөвлөсөн 130.0 сая төгрөг, төрийн байгууллагуудын ажилчдыг компьютер, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлоор хангахад төлөвлөсөн 650.0 сая төгрөг, Цэнгэл сумын Соёлын төвд тавилга, эд хогшил, тоног төхөөрөмж нийлүүлэхэд төлөвлөсөн 60.0 сая төгрөг, нийт **830.0** сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг хасах;
3. Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй хуулийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээнүүдийг хууль тогтоомжид нийцүүлэх;

АУДИТЫН ДҮНГЭЭР ДАРААХ САНАЛЫГ ХҮРГҮҮЛЖ БАЙНА.

1. Орон нутгийн төсвийн орлогыг 1,670.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх,
2. Төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх, зардлыг 1,310.0 сая төгрөгөөр бууруулах санал хүргүүлж байна.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

1. Орон нутгийн төсвийн зарим орлогыг үндэслэлтэй тооцож төлөвлөөгүй байна.
2. Орон нутгийн 2025 оны төсвийн төсөлд орлогыг 1,670.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх боломж байна.
3. Төсвийн нийт зарлагыг 4,261.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн байна.
4. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүдийг хууль тогтоомжид нийцүүлэн төлөвлөх шаардлагатай байна.